



**“ХӨРСНИЙ БОХИРДОЛ ҮҮССЭН ТАЛБАЙН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ,
СААРМАГЖУУЛАХ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ”
АЖЛЫН ДААЛГАВАР**

2024 оны 01 дүгээр
сарын 08-ны өдөр

№ НБОГ/2024-7

Улаанбаатар хот

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	
1.1. Захиалагч байгууллагын нэр, хаяг:	Нийслэлийн байгаль орчны газар Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Ц.Жигжиджавын гудамж-9, Бага тойруу-15160, Засаг захиргааны II байр 418 тоот
1.2. Санхүүжилтийн эх үүсвэр:	Нийслэлийн төсвийн хөрөнгө – Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардал
1.3. Төсөв:	300,000,000 (Гурван зуун сая) төгрөг
1.4. Төсөл хэрэгжих талбай:	Улаанбаатар хотын хэмжээнд хөрсний бохирдлыг саармагжуулах 15 га талбайг гүйцэтгэгч, захиалагчтай зөвшилцөж тогтооно.
1.5. Хамрах хүрээ:	Хөрсний бохирдол бууруулах 15 га нутаг дэвсгэр хамаарна.
1.6. Ажил гүйцэтгэх үндэслэл	<ul style="list-style-type: none">- “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого 9.2.1.2, 6.2.1.2. дахь зорилт;- “Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай” хуулийн 9.1. дэх заалтууд;- “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 6.2. дахь зорилт;- “Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-ний 252 дахь зорилт;- “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 5.2.6.2. дахь зорилт;- НБОГ-ын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 7 дахь заалт;
1.7. Ажлын зорилго:	Нийслэлийн нутаг дэвсгэрт хөрсний бохирдолтой 15 га талбайн бохирдлыг бууруулах

<p>1.8. Ажил гүйцэтгэх үе шат:</p>	<p>1-р үе шат: Бэлтгэл үе</p> <ul style="list-style-type: none"> - Ажил гүйцэтгэх хуваарьт төлөвлөгөө боловсруулан захиалагчаар баталгаажуулах; - Дүүргүүдээс санал болгох хөрсний бохирдолтой талбайн бохирдлын хэмжээг тодорхойлох - Итгэмжлэгдсэн лаборатори байх; /Өмнө ба дараа харьцуулах/ <ul style="list-style-type: none"> o Хүнд металлын үзүүлэлтүүд - Cr/хром/, Pb/хар тугалга/, Cd/кадми/, Zn/цайр/, Cu/зэс/, Ni/никель/, As/хүнсэл/, Co/кобальт/, Sr/Стронци/, V/бор/, Hg/мөнгөн ус/, Mo/молибден/. Эрүүл ахуйн үзүүлэлтүүд - Нянгийн тоо-E-Coli, Гэдэсний савханцрын титр, Анаэроб. <p>2-р үе шат: Хээрийн ажил</p> <ul style="list-style-type: none"> - Хөрсний бохирдолтой 15 га талбайд хэмжилт хийж, талбайг сонгох - Хөрсний судалгааны ажлууд, шинжилгээний дүнд үндэслэн хөрсний бохирдуулагч элементийн төрөл бохирдсон газрын хамрах талбай, бохирдлын үзүүлэлт, хөрсний шинж чанар, байгаль-цаг уурын нөхцөл зэрэгтэй уялдуулан бохирдлыг саармагжуулах арга зүй, технологийг боловсруулж батлуулах; <p>3-р үе шат: Ажил гүйцэтгэх</p> <ul style="list-style-type: none"> - Батлуулсан хөрсний бохирдлыг бууруулах арга, технологи, төлөвлөгөөний дагуу бохирдол бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх; - Хөрсний бохирдол бууруулсан талбайн хөрсний шинжилгээ хийж үр дүнг харьцуулан /өмнө ба дараа/ тайлагнах; - Хөрсний бохирдол бууруулсан талбайг хүлээлгэн өгөх; - Шинжилгээний дүн болон талбайн мэдээллийг нэгдсэн мэдээллийн санд оруулах; - Ажил гүйцэтгэлийг тайлагнах, үр дүнг үнэлүүлэх, холбогдох баримт бичгийг бүрэн хүлээлгэн өгөх;
<p>ХОЁР. ГҮЙЦЭТГЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА</p>	
<p>2.1. Чадвар</p>	<p>1. Ажил гүйцэтгэгч нь дараах байгууллагууд байж болно:</p> <ul style="list-style-type: none"> - Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага - Байгаль орчны үнэлгээ мөн газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийх тусгай зөвшөөрөлтэй байгууллага.

	<ul style="list-style-type: none"> - Нөхөн сэргээлт хийдэг газрын хэвлийн мэргэжлийн байгууллага - Судалгаа шинжилгээний хүрээлэн, төв - Их дээд сургууль - Тухай чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд түншлэл хэлбэрээр оролцож болно. <p>2. Ажил гүйцэтгэгч нь 3-с доошгүй жил үйл ажиллагаа явуулсан ажил гүйцэтгэх багийн бүрэлдэхүүнд мэргэжлээрээ 3 болон түүнээс дээш хугацаанд ажилласан туршлагатай</p> <ul style="list-style-type: none"> - үндсэн ажилтан байх - хөрс судлаач-1, ГМС мэргэжилтэн -1, химийн технологич-1, микробиологич-1 - гэрээт ажилтан байж болно - ургамал судлаач-1, биологич-1 байна. <p>3. Хөрсний бохирдлыг бууруулах, нөхөн сэргээлт хийхэд шаардлагатай хүн хүч, техник, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжтэй байна.</p> <p>Урьд өмнө нь ижил төстэй ажил гүйцэтгэж байсан бол давуу тал болно.</p>
<p>2.2. Техникийн болон бусад шаардлага:</p>	<ul style="list-style-type: none"> - “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл, тендерийн баримт бичигт заасан холбогдох шаардлагыг хангасан байх; - Мэргэжлийн байгууллагын тусгай зөвшөөрөл бүхий байгууллагуудын хувьд ажил гүйцэтгэхтэй холбоотой мэргэжлийн байгууллагын тусгай зөвшөөрөлийн хүчинтэй хугацаа дуусаагүй байх. Үүнд: <ul style="list-style-type: none"> o Засгийн газрын 2006 оны 137 дугаар тогтоолын хавсралт “Аж ахуй нэгж, байгууллагад байгаль орчны мэргэжлийн байгууллагын эрх олгох журам”-ын 2.1.6.газрын хэвлийн нөхөн сэргээлт хийх тусгай зөвшөөрөл байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас авсан; o Байгаль орчны үнэлгээний тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний эрхийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас авсан; o Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 191 дугаар тушаалаар батлагдсан “Газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрхийг хуулийн этгээдэд олгох, тэдгээрт хяналт тавих журам”-ын

	<p>1.7.1.Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа, газрын нөхөн сэргээлт хийх тусгай зөвшөөрлийг газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас авсан.</p> <ul style="list-style-type: none"> - Ажил гүйцэтгэхтэй холбоотой ХАБЭА-н дотоод дүрэм журамтай байх, аюулгүй байдлыг хангах - Хууль тогтоомжийн хүрээнд ажиллах; - Урьд өмнө нь ижил төстэй ажил гүйцэтгэж байсан бол давуу тал болно; - Хөрсний бохирдол, түүнийг бууруулах талаар судалгааны ажил гүйцэтгэх, хөрсийн дээж авах чадвартай байх; <p>Ажил гүйцэтгэл дууссаны дараа үр дүнд мониторинг судалгаа хийх чадвартай байх;</p>
<p>2.3. Тусгай шаардлага</p>	<ul style="list-style-type: none"> - Хөрсний бохирдлыг саамагжуулах ажлыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүн хүчтэй байна; - Ажил гүйцэтгэхэд шаардлагатай техник, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хүчин чадалтай байх; <ul style="list-style-type: none"> o газар хагалагч анжис, бутлагч, сийрүүлэгч, үр цацагч, хүрз, усалгааны систем гэх мэт.., - Мэргэжлийн, туршлагатай, чадварлаг хүний нөөцийн бүрэлдэхүүнтэй байх; - Хөрсний бохирдлыг саармагжуулсан талбайд ажил дууссаны дараах 2 жилд мониторинг судалгаа хийж хяналт тавих, тайлан мэдээг тухай бүр захиалагчид ирүүлэх;
<p>2.4. Холбогдох журам стандарт:</p>	<ul style="list-style-type: none"> - MNS 6341 : 2012 Хөрсний чанар. Хөрсөнд эрүүлзүйн нян судлалын шинжилгээ хийх арга; - MNS ISO 18400-203 : 2022 Хөрсний чанар. Сорьц авах 203-р хэсэг: Бохирдсон байх магадлалтай газрыг шинжлэх; - MNS ISO 18400-201 : 2022 Хөрсний чанар - сорьц авах 201-р хэсэг: Хээрийн нөхцөлд хөрсний сорьцыг урьдчилан боловсруулах; - MNS ISO 18400-105 : 2022 Хөрсний чанар. Сорьц авах 105-р хэсэг: Сорьц савлах, тээвэрлэх, агуулах, хадгалах; - MNS 5850 : 2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ; - MNS 3297 : 2019 Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх; - MNS ISO 11464 : 2002 Хөрсний чанар. Физик -химийн шинжилгээ хийх дээжийг урьдчилан


	<p>боловсруулах</p> <ul style="list-style-type: none"> - MNS 3675 : 1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга; - MNS 6838 : 2020 Байгаль орчин. Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах нефтийн бүтээгдэхүүнийг тодорхойлох жингийн арга; - MNS 5914 : 2008 Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо, тодорхойлолт
ГУРАВ. ХЯНАЛТ, ШАЛГАЛТ, ТАЙЛАН	
<p>3.1. Ажлын хяналт, шалгалт</p>	<ul style="list-style-type: none"> - Гэрээт ажлын гүйцэтгэлд захиалагч талаас хүлээн зөвшөөрч баталсан календарьчилсан төлөвлөгөө, холбогдох гэрээ болон ажлын даалгаврын дагуу гүйцэтгэж буй эсэхэд шууд болон дүүрэгтэй хамтран хяналт тавьж ажиллана. - Захиалагч нь шаардлагатай үед хэдийд ч гүйцэтгэгчийн ажилтай танилцах эрхтэй ба ажлын гүйцэтгэлтэй холбоотойгоор нэмэлт мэдээ мэдээлэл гаргуулж авах эрхтэй. - Хяналт, шалгалтын ажлыг захиалагч хариуцна.
<p>3.2. Тайлан материал хүлээлгэн өгөх</p>	<p>Гүйцэтгэгч байгууллага нь дараах тайлан, баримт бичиг материалыг захиалагч байгууллагаас томилогдсон ажлын хэсэгт хүлээлгэн өгнө. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын явцын тайланг сар бүр ирүүлэх /цаасаар болон цахимаар/; - Бүрэн хийж гүйцэтгэсэн ажлын тайланг хэвлэмэл болон цахим хэлбэрээр ирүүлэх; - Хөрсний шинжилгээний дүн мэдээг нэгтгэн, үнэлсэн баримт бичиг /шинжилгээний хариу эх хувиар/; - Мэдээллийн санд оруулсан мэдээлэл; - Хавсралт материалууд (фото зураг, бичлэг, хөрсний шинжилгээний дүнгийн эх хувь, бусад холбогдох материалууд); <p>Ажлын тайлан болон хавсралт материалуудыг эх хувь болон хуулбар 3 хувийг хэвлэмэл байдлаар ирүүлнэ. Бүх материалыг цахим хэлбэрээр хүлээлгэн өгөхдөө ажлын нэр, дугаар, хаягтай DVD-д хуулж ирүүлнэ;</p>
ДӨРӨВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА	
<p>4.1. Ажил эхлэх:</p>	<ul style="list-style-type: none"> - Гэрээ байгуулснаас хойш 5 сарын хугацаанд гүйцэтгэнэ;

	Гүйцэтгэгч нь ажлыг гүйцэтгэх календарьчилсан төлөвлөгөөг захиалагчид танилцуулан батлуулсны дараагаар ажлыг эхлүүлнэ;
--	--

Хянасан:

ХӨРСНИЙ БОХИРДОЛ, ДОРОЙТЛЫГ
БУУРУУЛАХ ХЭЛТСИЙН
ДАРГА

(албан тушаал)



Б.ЖАВЗАНДУЛАМ

(гарын үсэг)

Боловсруулсан:

ХӨРСНИЙ БОХИРДОЛ, ДОРОЙТЛЫГ
БУУРУУЛАХ ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

(албан тушаал)



Х.МӨНХЦЭЦЭГ

(гарын үсэг)